**МОНГОЛ УЛСЫН**
**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2021 оны 5 сарын 03 өдөр Дугаар 45 Улаанбаатар хот

**Саналын хуудасны тоо, загвар батлах нэгдсэн дугаар тогтоох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлин 54.1, 54.2, 54.3, 54.4, 54.5 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.6, 62.7 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.6 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 1/2958 тоот албан бичгээр ирүүлсэн сонгогчийн тоог үндэслэн ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн саналын хуудасны тоог 1 дүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа иргэдээс санал авах саналын хуудасны тоог Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасны дагуу хүсэлт гаргасан сонгогчийн тоонд үндэслэн 30 хувийн нөөцтэй байхаар тооцсугай.

3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн саналын хуудасны нэгдсэн дугаарыг 1 дүгээр хавсралтаар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа иргэдээс санал авах саналын хуудасны нэгдсэн дугаарыг 3 дугаар хавсралтаар тус тус тогтоосугай.

4.Саналын хуудсыг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, аймаг, дүүргийн сонгуулийн хороонд болон Төв комисст хүргүүлэхийг Ажлын хэсэг /Д.Даваа-Очир/-т даалгасугай.

ДАРГА П.ДЭЛГЭРНАРАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Д.ДАВАА-ОЧИР

00000091

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн
45 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН САНАЛЫН ХУУДАСНЫ НЭГДСЭН ДУГААР, ТОО

| Нэгдсэн дугаар | Аймаг | Сонгогчийн тоо | Саналын хуудасны тоо /10% нөөцтэй/ |
|---|---|---|---|
| АР-1 | Архангай | 62347 | 68,582 |
| БӨ-2 | Баян-Өлгий | 65897 | 72,487 |
| БХ-3 | Баянхонгор | 57287 | 63,016 |
| БУ-4 | Булган | 41709 | 45,880 |
| ГА-5 | Говь-Алтай | 37988 | 41,787 |
| ГС-6 | Говьсүмбэр | 11224 | 12,346 |
| ДА-7 | Дархан-Уул | 70099 | 77,109 |
| ДГ-8 | Дорноговь | 45660 | 50,226 |
| ДО-9 | Дорнод | 52957 | 58,253 |
| ДУ-10 | Дундговь | 31189 | 34,308 |
| ЗА-11 | Завхан | 47982 | 52,780 |
| ОР-12 | Орхон | 71060 | 78,166 |
| ӨВ-13 | Өвөрхангай | 75657 | 83,223 |
| ӨМ-14 | Өмнөговь | 45776 | 50,354 |
| СҮ-15 | Сүхбаатар | 41239 | 45,363 |
| СЭ-16 | Сэлэнгэ | 72914 | 80,205 |
| ТӨ-17 | Төв | 63735 | 70,109 |
| УВ-18 | Увс | 52499 | 57,749 |
| ХО-19 | Ховд | 56027 | 61,630 |
| ХӨ-20 | Хөвсгөл | 88089 | 96,898 |
| ХЭ-21 | Хэнтий | 51158 | 56,274 |
| **Аймгийн дүн** | | **1,142,493** | **1,256,745** |
| **Нэгдсэн дугаар** | **Дүүрэг** | **Сонгогчийн тоо** | **Саналын хуудасны тоо /5% нөөцтэй/** |
| БНД-22 | Багануур | 19620 | 20,601 |
| БХД-23 | Багахангай | 2920 | 3,066 |
| БГД-24 | Баянгол | 157065 | 164,919 |
| БЗД-25 | Баянзүрх | 252107 | 264,714 |
| НД-26 | Налайх | 25547 | 26,824 |
| СХД-27 | Сонгинохайрхан | 215705 | 226,492 |
| СБД-28 | Сүхбаатар | 100052 | 105,055 |
| ХУД-29 | Хан-Уул | 137557 | 144,435 |
| ЧД-30 | Чингэлтэй | 107478 | 112,852 |
| **Нийслэлийн дүн** | | **1,018,051** | **1,068,958** |
| **НИЙТ** | | **2,160,544** | **2,325,703** |

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 5. дугаар сарын 03-ний өдрийн
45 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2021

АР-1

## САНАЛЫН ХУУДАС

_____ аймаг/дүүрэг/улсын _____ - р хэсэг/салбар комисс

Та өөрийн сонгохыг хүссэн 1 нэр дэвшигчийн өмнөх зууван улаан дугуйг дүүргэн будаж саналаа тэмдэглэнэ үү. 1-ээс илүү нэр дэвшигчийн төлөө санал тэмдэглэсэн саналын хуудсыг хүчингүйд тооцохыг анхаарна уу.



Овог НЭР /Нам, эвслийн нэр/

Овог НЭР /Нам, эвслийн нэр/

Овог НЭР /Нам, эвслийн нэр/

Овог НЭР /Нам, эвслийн нэр/

**НЭГДСЭН ДУГААР** */АР-1, ЧД-1, Г-1 ... /*
*МУЕСТХуулиас. 54.5.Саналын хуудас нь тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.*

**САНАЛ ТЭМДЭГЛЭХ ЗААВАР**

*МУЕСТХуулиас 54.1.2.сонгогч саналаа тэмдэглэх тухай заавар агуулсан байна.*

**НЭР ДЭВШИГЧИЙН ЗУРАГ**

*МУЕСТХуулиас 54.3.Саналын хуудас нэр дэвшигчийн зураггай байна.*

**ДАЛД НУУЦЛАЛ**

- **Тусгай зориулалтын неон гэрлээр харагддаг, нүдэнд ил үл үзэгдэх UV будган нууцлал,**
- **усан хэв бүхий нууцлал**

*МУЕСТХуулиас 54.5.Саналын хуудас нь тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.*

*Democracy Suite сонгуулийн удирдлагын систем*

*Democracy Suite сонгуулийн удирдлагын систем*

**АЙМАГ, ДҮҮРГИЙН НЭР ХЭВЛЭГДСЭН БАЙНА.** /ДТГазрын нэр бичигдсан байна./

*Democracy Suite сонгуулийн удирдлагын систем*

**САНАЛ ТЭМДЭГЛЭХ ЗУУВАН УЛААН ДУГУЙ**

*Democracy Suite сонгуулийн удирдлагын систем*

**НЭР ДЭВШИГЧИЙН ОВОГ, НЭР**
*МУЕСТХуулиас 54.2.Саналын хуудсанд* ***нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг жижиг үсгээр, өөрийнх нь нэрийг том үсгээр бичих ба*** *нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэрийг бичнэ.*

**НЭР ДЭВШҮҮЛСЭН НАМ, ЭВСЛИЙН НЭР**
*МУЕСТХуулиас 54.2.Саналын хуудсанд нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэрийг жижиг үсгээр, өөрийнх нь нэрийг том үсгээр бичих ба нэр дэвшүүлсэн* ***нам, эвслийн нэрийг*** *бичнэ.*

*МУЕСТХуулиас 54.4.Нэр дэвшигчдийн нэрийг саналын хуудсанд бичихдээ нэр дэвшүүлсэн намуудын* ***Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дараалыг,*** *намууд хамтарч нэр дэвшүүлсэн бол* ***Улсын дээд шүүхэд эхэлж бүртгүүлсэн намын дараалыг баримтална.***

**ИЛ НУУЦЛАЛ / QR код /**

*Саналын хуудсын нэгдсэн дугаарын мэдээллийг агуулна.*

*МУЕСТХуулиас 54.5.Саналын хуудас нь тусгай нууцлалтай байх бөгөөд аймаг, дүүргийн хэмжээнд нэгдсэн дугаартай байна.*

Сонгуулийн ерөнхий хорооны
2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн
45 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
ГАДААД УЛСАД БАЙГАА ИРГЭДЭЭС САНАЛ АВАХ САНАЛЫН ХУУДАСНЫ НЭГДСЭН ДУГААР

| Нэгдсэн дугаар | Хот | Улс |
|---|---|---|
| | **Элчин сайдын яамд** | |
| Г-1 | Анкара | Бүгд Найрамдах Турк Улс |
| Г-2 | Бангкок | Тайландын Хаант Улс |
| Г-3 | Берлин | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс |
| Г-4 | Брюссель | Бельгийн Хаант Улс |
| Г-5 | Бишкек | Бүгд Найрамдах Киргиз Улс |
| Г-6 | Будапешт | Унгар Улс |
| Г-7 | Бээжин | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| Г-8 | Варшав | Бүгд Найрамдах Польш Улс |
| Г-9 | Вашингтон | Америкийн Нэгдсэн Улс |
| Г-10 | Вена | Бүгд Найрамдах Австри Улс |
| Г-11 | Вьентьян | Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс |
| Г-12 | Гавана | Бүгд Найрамдах Куба Улс |
| Г-13 | Дели | Бүгд Найрамдах Энэтхэг Улс |
| Г-14 | Каир | Арабын Бүгд Найрамдах Египет Улс |
| Г-15 | Канберра | Австралийн Холбооны Улс |
| Г-16 | Кувейт | Кувейт Улс |
| Г-17 | Лондон | Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс |
| Г-18 | Москва | Оросын Холбооны Улс |
| Г-19 | Минск | Бүгд Найрамдах Беларусь Улс |
| Г-20 | Нурсултан | Бүгд Найрамдах Казахстан Улс |
| Г-21 | Оттава | Канад Улс |
| Г-22 | Парис | Бүгд Найрамдах Франц Улс |
| Г-23 | Пхеньян | Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс |
| Г-24 | Прага | Бүгд Найрамдах Чех Улс |
| Г-25 | Ром | Бүгд Найрамдах Итали Улс |
| Г-26 | Софи | Бүгд Найрамдах Болгар Улс |
| Г-27 | Сөүл | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| Г-28 | Стокольм | Шведийн Хаант Улс |
| Г-29 | Сингапур | Бүгд Найрамдах Сингапур Улс |
| Г-30 | Токио | Япон Улс |
| Г-31 | Ханой | Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс |
| | **Байнгын төлөөлөгчийн газар** | |
| Г-32 | Женев | Швейцарийн Холбооны Улс |
| Г-33 | Нью-Йорк | Америкийн Нэгдсэн Улс |
| | **Ерөнхий консулын газар, Консулын газар** | |
| Г-34 | Истанбул | Бүгд Найрамдах Турк Улс |
| Г-35 | Сан-Франциско | Америкийн Нэгдсэн Улс |
| Г-36 | Осака | Япон Улс |
| Г-37 | Кызыл | Оросын Холбооны Улс |
| Г-38 | Улаан-Үд | Оросын Холбооны Улс |
| Г-39 | Эрхүү | Оросын Холбооны Улс |
| Г-40 | Хөх хот | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| Г-41 | Хонконг | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ЗЗОБ Хонконг |
| Г-42 | Шанхай | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| Г-43 | Эрээн | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| Г-44 | Пусан | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| Г-45 | Манжуур | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |